



**ИНД-19**

Иргэний Нисэхийн Багц Дүрэм

**Шилжилтийн дүрэм**

Иргэний нисэхийн ерөнхий газар

## **ДҮРМИЙН ТАЙЛБАР**

ИНД-19 нь дараах шаардлагыг багтаасан:

- шинэ дүрэм гарах хүртэл, ИНД болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдаагүй заалтууд;
- ХНД/IFR-ийн үйл ажиллагаанд GPS төхөөрөмжийг ашиглах.

Мөн, ИНД-19 нь дараах зохицуулалтыг тогтооно:

- тодорхой нисэхийн баримт бичгийн талаарх ИНЕГ-ын эрх;
- аэродромын цаг агаарын хязгаарлалт болон ХНД/IFR-ийн журам;
- аюулгүйн хамгаалалтын зохицуулалт;
- хувь хүний үнэмлэхжүүлэлтийн бусад шаардлага.

**Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-19-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-19, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл [www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn) веб сайтаас татаж авах боломжтой.**

## **Мэдээлэл**

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн энэхүү багц Дүрмийг боловсруулсан.

## **Өөрчлөлтийн түүх**

Анхны боловсруулалт

## **Хүчин төгөлдөр огноо**

2018 оны ... сарын ...

**Тэмдэглэл:** ИНД-19-ийн анхны боловсруулалтыг англи болон монгол хэл дээр, NZ Part 19 А.19-д үндэслэн боловсруулсан болно.

## Гарчиг

<b>А Бүлэг — Ерөнхий зүйл.....</b>	<b>5</b>
19.1. Тодорхойлолт.....	5
19.3. Хэмжлийн нэгж.....	5
19.5. Иргэний нисэхийн бэлгэ тэмдэг.....	5
19.7. Согтууруулах ундаа болон эм.....	6
19.9. Нэвтрэх бүсийн хяналт.....	6
19.11. Нисэхийн баримт бичгийг бусдад шилжүүлэх.....	6
19.13. Нөөц.....	6
19.15. Гадаадын агаарын хөлгийн Монгол Улс дахь үйл ажиллагаа.....	6
<b>В Бүлэг — Үйл ажиллагааны ерөнхий дүрэм.....</b>	<b>7</b>
19.103. Хөдөө аж ахуйн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгч – статистик мэдээ.....	7
19.105. Нисгэгчгүй агаарын хөлөг.....	7
19.107. Нөөц.....	7
<b>С Бүлэг — Нөөц.....</b>	<b>8</b>
<b>Д Бүлэг — ХНД/IFR-ийн үйл ажиллагаа: GNSS.....</b>	<b>8</b>
19.201. Хамрах хүрээ.....	8
19.203. Тайлбар.....	8
19.205. Нисгэгчийн мэргэшил.....	9
19.207. Анхдагч хэлбэрийн GPS үйл ажиллагаа.....	9
19.209. Бие даасан GPS үйл ажиллагаа.....	10
19.211. Нэмэлт GPS үйл ажиллагаа.....	10
19.213. GPS-ээс авсан зайн мэдээлэл.....	11
19.215. Минимум нислэгийн түвшин.....	11
19.217. Үнэлгээ хийгдээгүй замын нислэг.....	11
19.219. Нислэгийн төлөвлөгөө.....	12
<b>Е Бүлэг — Нөөц.....</b>	<b>12</b>
<b>Ғ Бүлэг — Хангамжийн байгууллагын зөвшөөрөл.....</b>	<b>12</b>
<b>Г Бүлэг — Аюулгүйн хамгаалалт.....</b>	<b>13</b>
19.353. Аюулгүйн хамгаалалтын хяналт хийгдэх агаарын хөлөг болон хувь хүнд хамаарах хязгаарлалт.....	13
19.355. Хориглох зүйлс.....	13
19.357. Нисэх буудлын нэвтрэх үнэмлэх.....	13
19.359. Шүүхийн, эсхүл захиргааны журмаар аялах зорчигч.....	15
<b>И Бүлэг — Ажилтан.....</b>	<b>15</b>
19.401. Техник үйлчилгээний ажилтны үнэмлэхийг дахин шалгах.....	15
19.403. Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн ажлын цагийн хязгаарлалт.....	15
19.405. Туршин нисгэгч.....	15
19.407. Нөөц.....	16
19.409. Глайдерын ажилтан.....	16
19.411. Ханг-глайдер болон параглайдерын нисгэгч.....	17
19.413. Микролайтын нисгэгч.....	17

## А Бүлэг — Ерөнхий зүйл

### 19.1. Тодорхойлолт

Агуулгыг өөрөөр шаардсанаас бусад тохиолдолд, энэ Дүрэмд:

**Нисэх буудлын нэвтрэх үнэмлэх** гэж энэ Дүрмийн дагуу олгосон, эсхүл зөвшөөрсөн нисэх буудлын нэвтрэх үнэмлэхийг;

**Үйл ажиллагааны бүс** гэж үйл ажиллагааны бүсийн таних тэмдгээр тодорхойлсон, эсхүл үйл ажиллагааны байгууламж байрласан бүсийг багтаасан, агаарын хөлөг хөдөлгөөн, эсхүл маневр хийдэг аэродром дээрх аливаа талбайг;

**Шилжүүлэх мэдэгдэл** гэж нийлүүлсэн нисэхийн бүтээгдэхүүн нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц нислэгт тэнцэх чадварын стандартад тохирч байгааг, тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түгээлт болон техник үйлчилгээний шатанд эргэж тогтоох замаар нотлох боломж олгож байгаа баримт бичгийг.

### 19.3. Хэмжлийн нэгж

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, Монгол Улсад нисэхийн зорилгоор ашигладаг хэмжлийн нэгж нь Олон улсын нэгжийн системд заасан бөгөөд Конвенцийн Хавсралт 5-д хэрэглэдэг.

(b) Хавсралт 5-д хэрэглэж буй Олон улсын нэгжийн системийн бус нэгжийг дараах хүснэгтэд заасны дагуу Монгол Улсад ашиглана:

зай (distance)	далайн миль / nautical mile	NM
түвшин, өндөрлөг болон өндөр (агаарын хөлгийн үйл ажиллагааны хувьд)	фут / foot	ft
салхины хурдыг багтаасан хурд	кнот / knot	kt
босоо хурд	фут минут / foot per minute	ft / min

### 19.5. Иргэний нисэхийн бэлгэ тэмдэг

(a) Монгол Улсын иргэний нисэхийн бэлгэ тэмдгийн загварыг Дарга батална.

(b) Монгол Улсын иргэний нисэхийн бэлгэ тэмдгийг, дараахаас бусад зүйл дээр аливаа хэлбэрээр байрлуулахгүй:

- (1) ИНЕГ, түүний харъяа байгууллагын албан байр болон тээврийн хэрэгсэлд;
- (2) ИНЕГ-ын харъяа байгууллагын аливаа агаарын навигацийн байгууламж дээр;
- (3) ИНЕГ-ын харъяа байгууллагын аливаа аэродромын барилга байгууламж дээр;
- (4) ИНЕГ-аас гаргаж буй аливаа албан захидал болон баримт бичигт;

(5) Даргын бичгээр олгосон зөвшөөрөлд заасан нөхцөлийн дагуу.



### **19.7. Согтууруулах ундаа болон эм**

Багийн аливаа гишүүн албан үүргээ гүйцэтгэж байхдаа согтууруулах, тайвшруулах, өвчин намдаах, мансууруулах, эсхүл хүч оруулах бодис, эсхүл бэлдмэл хэрэглэсэн, эсхүл ашигласны улмаас эрүүл мэндийн байдал нь ажил үүргээ гүйцэтгэх чадварыг бууруулсан, эсхүл мансуурсан байдалтай байхыг хориглоно.

### **19.9. Нэвтрэх бүсийн хяналт**

Хуулиар Даргад олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор, Дарга тухайн арга хэмжээг анхаарах шаардлагатай гэж үзсэн аливаа бүс, эсхүл газарт нэвтрэх хяналтыг, эсхүл хоригийг ИНД-140-ийн дагуу эрх олгосон этгээд тавьж болно.

### **19.11. Нисэхийн баримт бичгийг бусдад шилжүүлэх**

- (a) Нисэхийн баримт бичгийг бусдад шилжүүлэхийг хориглоно.
- (b) Шилжүүлсэн нисэхийн баримт бичиг нь түүнийг шилжүүлэн авсан этгээдэд эрх олгохгүй.

### **19.13. Нөөц**

### **19.15. Гадаадын агаарын хөлгийн Монгол Улс дахь үйл ажиллагаа**

- (a) Энэ зүйлийн (b)-ийн нөхцөлийг харгалзан, нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд хэрэгтэй гэж үзэн Дарга тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаанд тогтоож болох нөхцөл болон хязгаарлалт бүхий зөвшөөрөлтэйгээс бусад тохиолдолд, гадаадад бүртгэгдсэн агаарын хөлгөөр агаарын тээврийн үйл ажиллагаанаас бусад, хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагааг Монгол Улсад эрхлэхгүй.
- (b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу олгосон зөвшөөрөл эзэмшигч нь тухайн зөвшөөрөлд заасан аливаа нөхцөл, эсхүл хязгаарлалтыг мөрдөнө.
- (c) Энэ зүйл нь, олон улсын хуваарьт, эсхүл олон улсын хуваарьт бус нислэг үйлдэж буй агаарын хөлөгт хамаарахгүй.

## В Бүлэг — Үйл ажиллагааны ерөнхий дүрэм

### 19.103. Хөдөө аж ахуйн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгч – статистик мэдээ

(а) Хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч бүр дараах мэдээллийг агуулсан тайланг, Хүснэгт 1-д заасан хамрах хугацаанд, тайлан ирүүлэх эцсийн хугацаанаас өмнө Даргад ирүүлнэ:

- (1) тухайн мэдээний хамарсан хугацаа;
- (2) тухайн гэрчилгээ эзэмшигчийн нэр;
- (3) тухайн агаарын хөлгийн бүртгэлийн таних тэмдэг;
- (4) тухайн тайлангийн хугацаанд ачаа тээвэрлэсэн тоо;
- (5) тухайн тайлангийн хугацаанд ашигласан аэродром бүрийн байрлал;
- (6) ургамлын тэжээл, хөрсний бордоо, ургамлын тархалт, эсхүл хортонтой тэмцэх зорилгоор хөдөө аж ахуйн химийн бэлдмэл, эсхүл бусад бодис цацах нислэгийн үйл ажиллагаа бүрийн:
  - (i) тухайн тээвэрлэсэн ачааны төрөл;
  - (ii) тухайн ачааны нийт жин, эсхүл хэмжээ;
  - (iii) нийт тооцоолсон боловсруулагдсан газрын талбай.

(б) Энэ зүйлийн (а)-ийн дагуу шаардсан статистик мэдээллийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц цахим, эсхүл бичгийн хэлбэрээр ирүүлнэ.

#### Хүснэгт 1. Тайлангийн хугацаа

Тайлан	Хамрах хугацаа	Тайлан ирүүлэх хугацаа
1-р улирал	01 сарын 01-нээс 03 сарын 31	05 сарын 01
2-р улирал	04 сарын 01-нээс 06 сарын 30	08 сарын 01
3-р улирал	07 сарын 01-нээс 09 сарын 30	11 сарын 01
4-р улирал	10 сарын 01-нээс 12 сарын 31	02 сарын 01

### 19.105. Нисгэгчгүй агаарын хөлөг

[Хүчингүй]

### 19.107. Нөөц

## С Бүлэг — Нөөц

## Д Бүлэг — ХНД/IFR-ийн үйл ажиллагаа: GNSS

### 19.201. Хамрах хүрээ

(a) Энэ Бүлэг нь GNSS төхөөрөмжийг ХНД/IFR-ийн дагуу ашиглах нөхцөл болон шаардлагыг тогтооно.

(b) Энэ Бүлэгт багтсан нөхцөл болон журам нь энэ дүрэм, эсхүл бусад холбогдох ИНД-д заасан аливаа бусад шаардлагад нэмэлт болно.

### 19.203. Тайлбар

Энэ Бүлэгт хамаарах нэр томъёоны тайлбар:

**GPS өгөгдлийн сан:** нисэх буудал, навигацийн туслах илтгэх цэг, хэрэглэлээр нисэн гарах стандарт, хэрэглэлээр нисэн ирэх стандарт, хэрэглэлээр ойртолт үйлдэх, тусгай зориулалтаар ашиглах агаарын зайн талаар болон нисгэгчид хэрэгцээтэй бусад эд зүйлсийг агуулсан цахим ой санамж;

**GLONASS:** Глобал навигацийн хиймэл дагуулын системийн ОХУ-ын хэсэг;

**GNSS:** Глобал навигацийн хиймэл дагуулын систем;

**GPS:** Глобал байршил тогтоох систем;

**GPS мэдрэгч (GPS sensor):** FMS-ийн хүрээнд навигацид ашиглагдах GPS нэгж төхөөрөмж;

**NANU:** NAVSTAR хэрэглэгчид хандсан анхааруулах мэдэгдэл (GPS NOTAM);

**Анхдагч хэлбэрийн навигацийн систем (Primary-means navigation system):** өгөгдсөн үйл ажиллагаа, эсхүл нислэгийн үе шатанд нарийвчлал болон бүрэн бүтэн байдлын шаардлагыг хангах ёстой, гэхдээ үйлчилгээний бэлэн болон тасралтгүй байх шаардлагыг хангахгүй байж болох зөвшөөрөгдсөн навигацийн систем. Нислэгийг тодорхой цаг хугацааны үечлэлд хувааж, түүнд тохирох журмын хязгаарлалтаар аюулгүй байдлыг хангадаг;

**RAIM (хүлээн авагчийн бие даасан, бүрэн бүтэн байдлын хяналт) / (receiver autonomous integrity monitoring):** нислэгийн үе шатанд хамаарах GPS-ийн байршлын бүрэн бүтэн байдлын үзүүлэлтийн TSO-ын шаардлагаас хэтэрсэн байрлалын алдааг илрүүлэх нислэгийн GPS хүлээн авагч/процессорын ажиллагаа. Энэ нь шаардлагатай үед ил харагдах, эсхүл анхааруулах дуут дохио өгнө;

**RAIM Анхааруулга (RAIM боломжгүй гэсэн мэдээ) / (RAIM not available message):** GPS хиймэл дагуулаас авсан навигацийн байршлын сонголтын бүрэн бүтэн байдал найдваргүй болохыг анхааруулах дохио;

**Бие даасан навигацийн систем (Sole-means navigation system):** нарийвчлал, бүрэн бүтэн байдал, бэлэн болон тасралтгүй байх навигацийн системийн бүх 4 үзүүлэлтийн шаардлагыг, уг үйл ажиллагаа, эсхүл нислэгийн үе шатанд тухайн



агаарын хөлөг хангах боломж олгох ёстой, өгөгдсөн үйл ажиллагаа, эсхүл нислэгийн үе шатанд зөвшөөрөгдсөн навигацгийн системийг;

**Нэмэлт навигацгийн систем / Supplemental means navigation system:** бие даасан хэлбэрийн навигацгийн системтэй заавал хамт ашиглах навигацгийн системийг.

#### 19.205. Нисгэгчийн мэргэшил

(a) GPS хэрэглэлийн ойртолтод ашигладаг аливаа FMS-ийг багтаасан, GPS хүлээн авагчийн маяг болон загварыг ашиглах ур чадвараа амжилттай харуулсныг шалгах-нисгэгч нисгэгчийн дэвтэрт нь гэрчилгээжүүлээгүй тохиолдолд хөлгийн дарга ХНД/IFR-ээр GPS хүлээн авагч ашиглан хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг мөрдөхгүй.

(b) Хэрэв тухайн нисгэгч нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц стандартын дагуу GPS хүлээн авагч, эсхүл FMS-ийг ашиглах мэдлэг болон ур чадвараа харуулах нислэгийн шалгалтыг амжилттай гүйцэтгэсэн бол шалгах-нисгэгч GPS хүлээн авагч, эсхүл FMS-ийн маяг болон загварыг нисгэгчийн дэвтэрт нь бичнэ.

#### 19.207. Анхдагч хэлбэрийн GPS үйл ажиллагаа

GPS-ийг анхдагч хэлбэрийн навигацгийн системээр ашиглан, ХНД/IFR-ээр агаарын хөлгөөр үйл ажиллагаа явуулж буй этгээд бүр нь:

- (1) дараах нөхцөлийг бататгана:
  - (i) CAA 2129 маягтад тухайн GPS төхөөрөмж нь 1-р түвшинд зөвшөөрөгдсөнийг;
  - (ii) зорьж буй ХНД/IFR-ийн үйл ажиллагаанд GPS төхөөрөмжийг үндсэн хэлбэрийн навигацгийн системээр ашиглахыг зөвшөөрч, тухайн агаарын хөлгийн CAA 2129 маягтад бичилт хийснийг;
- (2) тухайн GPS төхөөрөмжийг тухайн агаарын хөлгийн нислэгийн заавар, эсхүл агаарын хөлгийн нислэгийн зааврын нэмэлтийн дагуу ажиллуулна;
- (3) хэрэв тухайн агаарын хөлөг нь Монгол Улсын нислэгийн мэдээллийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа бол, тухайн агаарын хөлгийг дараах байдлаар тоногლოსныг бататгана:
  - (i) агаарын тээврийн үйл ажиллагааны хувьд, GPS хүлээн авагчаас гадна ажиллагаатай, бие даасан хэлбэрийн 2 навигацгийн системээр. Бие даасан хэлбэрийн навигацгийн систем нь тухайн нисэж буй замд тохирсон байх ёстой;
  - (ii) агаарын тээврийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааны хувьд, GPS хүлээн авагчаас гадна, ажиллагаатай, бие даасан хэлбэрийн 1 навигацгийн системээр. Тухайн бие даасан хэлбэрийн навигацгийн систем нь тухайн нисэж буй замд тохирсон байх ёстой;
- (4) хэрэв GPS-д суурилсан хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг ашиглахыг зорьж байгаа бол, нисэн хүрэх цэгт ирэх тухайн баримжаалсан цагийн RAIM урьдчилсан мэдээг нисэн гарахаас өмнө дараах байдлаар авна:

- (i) тухайн агаарын хөлгийн GPS хүлээн авагчаас; эсхүл
  - (ii) ИНД-172-ийн дагуу олгосон НХУ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигчээс;
- (5) нислэгийн замын дагуух болон аэродромын навигацийг дараах байдлаар гүйцэтгэж байгааг бататгана:
- (i) тухайн нисэж буй замд тохирсон хүчинтэй нислэгийн замын болон бүсийн зурагтай холбоотой үнэн зөв өгөгдөл агуулсан GPS өгөгдлийн санг ашиглан;
  - (ii) GPS бүрийн өгөгдлийн сангийн сонгосон зам болон илтгэх цэгүүдийн хоорондын зайн нарийвчлал болон үндэслэлийг нислэгийн замын болон бүсийн хүчинтэй зурагтай тулган шалгах замаар;
- (6) бүх GPS хэрэглэлийн ойртолтыг, тухайн нисэж буй ойртолт үйлдэх журмын Хэрэглэлээр ойртолт үйлдэх хэвлэгдсэн зурагтай холбоотой хүчинтэй, үнэн зөв өгөгдлийг агуулсан GPS өгөгдлийн санг ашиглан хэрэглэлээр ойртолт үйлдэх зөвшөөрөгдсөн журмын дагуу гүйцэтгэснийг бататгана;
- (7) хэрэв, тухайн нислэгийн замын үе шатанд RAIM анхааруулга 10 минутаас дээш хугацаагаар дэлгэцэнд мэдээлсэн, эсхүл тухайн GPS төхөөрөмж DR горимд 1 минутаас дээш хугацаагаар ажиллагаатай байсан бол:
- (i) хяналт тавьж буй зохих НХУ-ын үйлчилгээний байгууллагад мэдэгдэнэ;
  - (ii) ХНД/IFR-ээр зөвшөөрөгдсөн өөр навигацийн систем ашиглан тухайн агаарын хөлгийн байрлалыг 10 минут тутамд бататгана;
- (8) RAIM анхааруулга дэлгэцэнд гарсан үед хэрэглэлийн ойртолтыг эхлүүлэхгүй;
- (9) хэрэв ИНД-91.405-ын дагуу нөөц аэродром шаардлагатай бол дараах нөхцөлийг бататгана:
- (i) тухайн нөөц аэродром нь GPS навигацаас өөр, бүрэн ажиллагаатай радио навигацийн төхөөрөмжид суурилсан, хэрэглэлээр ойртолт үйлдэх зарлагдсан журмаар үйлчилдэг болохыг;
  - (ii) тухайн агаарын хөлөг нь уг радио навигацийн төхөөрөмжийг ашиглах чадвартай навигацийн төхөөрөмжөөр тоноглогдсоныг.

#### **19.209. Бие даасан GPS үйл ажиллагаа**

(a) Этгээд нь Монгол Улсын нислэгийн мэдээллийн бүсэд зөвхөн GPS мэдрэгч ашигладаг, бие даасан хэлбэрийн навигацийн систем ашиглан агаарын хөлгөөр ХНД/IFR-ийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.

#### **19.211. Нэмэлт GPS үйл ажиллагаа**

(a) Аливаа этгээд, 19.207(1)-ийн ХНД/IFR-ийн навигацийн шаардлага хангаагүй GPS хүлээн авагч ашиглан агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.

(b) Этгээд нь ХНД/IFR-ээр үйл ажиллагаа гүйцэтгэж байхдаа, 19.207(1)-ийн шаардлага хангаагүй GPS хүлээн авагчийг зөвхөн нэмэлт мэдээлэл авахаар ашиглаж болно.

### **19.213. GPS-ээс авсан зайн мэдээлэл**

(a) Хэрэв RAIM боломжгүй, мөн өмнөх 10 минутын хугацаанд боломжгүй байсан бол ХНД/IFR-ээр GPS төхөөрөмж ашиглан үйл ажиллагаа явуулж буй агаарын хөлгийн дарга нь GPS-ээс авсан зайн мэдээлэл ашиглахыг хориглоно.

(b) Хөлгийн дарга байрлалаа илтгэхдээ, GPS-ээс авсан зайн мэдээлэл ашиглаж байгаа бол, тухайн зай нь GPS өгөгдлийн санд агуулагдаж буй тогтоосон баримжаат цэгт хамааралтай GPS-ийн зай болохыг тодорхойлон заах үүрэгтэй.

(c) Хөлгийн дарга GPS-ээс авсан зайн мэдээллийг ILS/DME, эсхүл LOC/DME хэрэглэлээр ойртолт үйлдэх журамд ашиглаж байгаа бол, дараах нөхцөлийг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн GPS-ын зайн мэдээлэл нь тухайн хэрэглэлээр ойртолт үйлдэх хэвлэгдсэн журамтай холбоотой тухайн DME-ийн солбилцолд суурилсныг;
- (2) DME-ийн солбилцлын тухайн үеийн мэдээллийг GPS өгөгдлийн санд байнгын хэлбэрээр хадгалдаг болохыг.

### **19.215. Минимум нислэгийн түвшин**

Энэ Дүрмийн дагуу зарласан минимум нислэгийн түвшинг үл харгалзан, GPS төхөөрөмжийг анхдагч хэлбэрийн навигацийн системээр, эсхүл бие даасан хэлбэрийн навигацийн системээр ашиглан, ХНД/IFR-ээр үйл ажиллагаа явуулж буй агаарын хөлгийн хувьд минимум нислэгийн түвшин гэж:

- (1) НХУ-ын зөвшөөрөлд багтсан, зохих НХУ-ын нэгжээс тогтоосон тухайн түвшинг; эсхүл
- (2) нислэгийн замын зураг, бүсийн зурагт үзүүлсэн, эсхүл хүснэгтэд үнэлэгдсэн боловч Монгол Улсын AIP-д зурагдаагүй, зарлагдсан замын хувьд, дараах өндөрт, эсхүл дараах өндрөөс дээш байх аяллын түвшний ХНД/IFR-ийн хүснэгтээс сонгосон хамгийн бага түвшин:
  - (i) тухайн замын минимум аюулгүй түвшин (MSA);
  - (ii) хязгаарласан минимум огтлох түвшин;
  - (iii) тухайн замд нөлөөлдөг аливаа галт уулын аюултай зоон, аюултай бүс, цэргийн үйл ажиллагааны бүс, эсхүл хязгаарлалттай бүсийн дээд хязгаар.

### **19.217. Үнэлгээ хийгдээгүй замын нислэг**

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, Монгол Улсын нислэгийн мэдээллийн бүсэд ХНД/IFR-ээр GPS төхөөрөмжийг анхдагч хэлбэрийн навигацийн системээр ашиглан үйл ажиллагаа гүйцэтгэж буй агаарын хөлгийн даргад, хэрэв дараах бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа бол, төлөвлөөгүй нислэгийн зам сонгохыг зөвшөөрнө:

(1) 4200 м (FL140), эсхүл түүнээс дээш, тогтоосон уулархаг бүсийн хүрээнд;  
эсхүл

(2) 3000 м (FL100), эсхүл түүнээс дээш, бусад агаарын зайд.

(b) Хэрэв НХУ-аас зөвшөөрсөн бол, хяналттай агаарын зайд төлөвлөөгүй нислэгийн зам сонгохыг агаарын хөлгийн даргад зөвшөөрнө.

(c) ХНД/IFR-ээр GPS төхөөрөмжийг анхдагч хэлбэрийн навигацийн системээр ашиглан үйл ажиллагаа гүйцэтгэж буй агаарын хөлгийн даргад 3000 м (FL100)-ээс доош төлөвлөөгүй нислэгийн зам сонгохыг зөвшөөрнө, хэрэв:

(1) НХУ зөвшөөрсөн бол;

(2) тухайн нислэг хангалттай саад давах өндөрт байгааг НХУ локатораар тасралтгүй хянадаг бол.

### **19.219. Нислэгийн төлөвлөгөө**

(a) Хэрэв “G” үсэг тухайн нислэгийн төлөвлөгөөний 10-р нүдэнд бичигдсэн бол хөлгийн дарга зөвхөн ХНД/IFR-ээр GPS төхөөрөмжийг анхдагч хэлбэрийн навигацийн системээр, эсхүл бие даасан хэлбэрийн навигацийн системээр ашиглан үйл ажиллагаа гүйцэтгэх үүрэгтэй.

(b) Энэ Бүлгийн шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, этгээд нь тухайн нислэгийн төлөвлөгөөний 10-р нүдэнд “G” үсэг бичихийг хориглоно.

## **E Бүлэг — Нөөц**

## **F Бүлэг — Хангамжийн байгууллагын зөвшөөрөл**

Энэ Бүлэг ИНД-145-д шилжсэн.

## **G Бүлэг — Аюулгүйн хамгаалалт**

### **19.353. Аюулгүйн хамгаалалтын хяналт хийгдэх агаарын хөлөг болон хувь хүнд хамаарах хязгаарлалт**

ИНД-91.9-ийн дагуу Дарга эрх олгосноос бусад тохиолдолд, этгээд нь дараах эд зүйлийг аюулгүйн хамгаалалтын хяналтаар орсон этгээдэд дамжуулахгүй, эсхүл аюулгүйн хамгаалалтын хяналт хийгдсэн агаарын хөлгийн бүхээгт байгаа аливаа этгээд авах боломжтой байрлалд байрлуулахгүй:

- (1) галт зэвсэг;
- (2) аюултай, эсхүл хор хөнөөл учруулах зэвсэг, эсхүл эдгээрийн аливаа төрлийн хэрэгсэл;
- (3) сум хэрэгсэл;
- (4) тэсрэх бодис, эсхүл хэрэгсэл, эсхүл гэмтэл учруулах бодис, эсхүл агаарын хөлгийн, эсхүл агаарын хөлгийн бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдалд аюул учруулахад ашиглагдах аливаа төрлийн хэрэгсэл.

### **19.355. Хориглох зүйлс**

Хуулиар эрх олгогдоогүй бол, аливаа этгээдэд:

- (1) аливаа аюулгүйн хамгаалалттай бүс, өндөржүүлсэн хамгаалалттай бүс, эсхүл үйл ажиллагааны бүсэд нэвтрэх боломжийг хянах аливаа хаалга, хашаа, эсхүл аэродромын бусад хаалт, хашааг нээлттэй, эсхүл хамгаалалтгүй, эсхүл бусад хэлбэрээр хяналтгүй үлдээх; эсхүл
- (2) аливаа аюулгүйн хамгаалалттай бүс, өндөржүүлсэн хамгаалалттай бүс, эсхүл үйл ажиллагааны бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэхээс сэргийлэхэд ашиглагдаж байгаа аливаа хашаа, хаалт, эсхүл бусад зүйлийн хажууд, эсхүл дээр нь хяналтын арга хэмжээнээс зайлсхийх боломж олгох аливаа эд зүйлийг урьдчилан байрлуулах, тавих, эсхүл үлдээхийг хориглоно.

### **19.357. Нисэх буудлын нэвтрэх үнэмлэх**

(a) Дараах тохиолдолд Дарга нисэх буудлын нэвтрэх үнэмлэх, эсхүл бусад нэвтрэх баримт бичгийг энэ дүрмийн дагуу олгож, эсхүл зөвшөөрч болно, хэрэв:

- (1) Дарга үнэмлэх, эсхүл баримт бичиг авах хүсэлт гаргасан этгээдийг тодорхойлох аюулгүйн хамгаалалтын зохих шалгалтыг хуулийн дагуу хийсэн бол; эсхүл
- (2) тухайн этгээд, Даргын хүлээн зөвшөөрөхүйц аюулгүйн хамгаалалтын өөр шалгалтад тэнцсэн гэж Дарга шийдвэрлэсэн бол.

(b) Энэ зүйлийн (c) болон (g)-г харгалзан, дараахаас бусад тохиолдолд аливаа этгээд аюулгүйн хамгаалалттай аэродром, эсхүл аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламжийн аливаа хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн хамгаалалттай бүсэд нэвтрэх, эсхүл бүсэд байхыг хориглоно:

- (1) нисэх буудлын нэвтрэх үнэмлэхийг хувцасны гадна энгэрт, ил харагдахаар зүүсэн байх; эсхүл
- (2) энэ зүйлийн (а)-ийн дагуу тухайн цаг хугацаанд эрх олгосон өөр нэвтрэх баримт бичиг, эсхүл өөрөө ашигладаг бусад нэвтрэх баримт бичгийг авч явах.
- (с) Дарга, нисэх буудлын нэвтрэх үнэмлэх эзэмшигчийн нэрийг ил болгохгүй байх нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд үнэмлэх эзэмшигчийн нэрийг арилгасан нэвтрэх үнэмлэх зүүхийг зөвшөөрч болно.
- (d) Энэ дүрмийн дагуу аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн хамгаалалттай бүсэд нэвтрэх эрх олгогдсон этгээд нь зөвхөн албан үүргийн зорилгоор тухайн бүсэд байж болно.
- (e) Хэрэв эрх бүхий этгээд шаардвал аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн хамгаалалттай бүсэд нэвтрэх аливаа этгээд нь нисэх буудлын нэвтрэх үнэмлэх, эсхүл энэ зүйлийн (а)-ийн дагуу эрх олгосон бусад нэвтрэх баримт бичгийг шалгуулна.
- (f) Хэрэв нисэх буудлын нэвтрэх үнэмлэх эзэмшигч нь тухайн үнэмлэх шаардлагатай албан тушаалд ажиллахаа больсон, эсхүл бусад шалтгаанаар үнэмлэх эзэмших эрхгүй болсон бол үнэмлэх эзэмшигч үнэмлэхээ олгосон эрх бүхий байгууллагад нэн даруй эргүүлэн өгнө.
- (g) Энэ зүйлийн (b) нь дараах этгээдэд хамаарахгүй:
- (1) тухайн этгээдийн байнга оршин суудаг улсын засгийн газар, эсхүл ажил олгогчийн олгосон албан ёсны нэвтрэх үнэмлэхийг гадуур хувцсандаа зүүсэн олон улсын үйлчилгээнд явж буй агаарын хөлгийн багийн аливаа гишүүнд; эсхүл
- (2) тухайн этгээдийн албан үүргийн шаардлагаар нууцлахыг шаардсан Монгол Улсын засгийн газрын агентлагийн аливаа албан тушаалтанд; эсхүл
- (3) хэрэв аливаа этгээд нь тухайн нислэгийн хүчинтэй суугчийн тасалбартай, эсхүл багийн гишүүнийг, эсхүл үйл ажиллагаа эрхлэгчийн төлөөлөгчийг дагалдаж яваа бол тухайн нислэгээр явахаар, эсхүл нислэгээс буугаад аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн хамгаалалттай бүсэд нэвтрэх, эсхүл бүсээс гарах аливаа зорчигчид; эсхүл
- (4) хэрэв тухайн нисгэгч нь нисгэгчийн хүчинтэй үнэмлэхтэй, эсхүл аливаа этгээд тухайн нисгэгчийг дагалдаж байгаа бол, тухайн агаарын хөлөгт суух, буух, эсхүл үйлчилгээ хийх зорилгоор хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн хамгаалалттай бүсэд нэвтрэх, эсхүл бүсэд байгаа, хувийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй агаарын хөлгийн даргад.
- (h) Хэрэв нэвтрэх үнэмлэх авах хүсэлт гаргасан этгээдэд Дарга аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн хамгаалалттай бүсэд нэвтрэх, эсхүл бүсэд байх түр нэвтрэх үнэмлэхийг, 19.357(а)(1) болон (2)-д дурьдсан аюулгүйн хамгаалалтын шалгалтын үйл явцын дагуу нисэх буудлын нэвтрэх үнэмлэхтэй этгээд дагалдахаар олгосон бол, тухайн этгээдэд 19.357(а)(1) болон (2)-д дурьдсан аюулгүйн хамгаалалтын шалгалт хийхийг шаардахгүй.

**19.359. Шүүхийн, эсхүл захиргааны журмаар аялах зорчигч**

(a) Хэрэв Монгол Улсын, эсхүл гадаад улсын Засгийн газрын байгууллагаас, тухайн этгээдийг агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж буй агаарын хөлгөөр шүүхийн, эсхүл захиргааны журмаар аялуулахыг шаардаж байгаа нөхцөлд тухайн этгээд харгалзагчтай аялах эсэхээс үл хамааран, тухайн санал болгосон аяллын нөхцөл байдлын талаар үйл ажиллагаа эрхлэгчид мэдээлнэ.

(b) Хэрэв үйл ажиллагаа эрхлэгч тухайн аяллыг гүйцэтгэхийг зөвшөөрсөн тохиолдолд:

(1) үйл ажиллагаа эрхлэгчийн нислэгийн аюулгүй байдлын үүднээс шаардлагатай гэж үзсэн, ИНД-119, эсхүл ИНД-129-ийн дагуу батлагдсан аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрөөр зөвшөөрсөн аливаа нөхцөлийг тогтооно;

(2) тухайн хөлгийн даргад мэдэгдэнэ.

(c) Холбогдох байгууллага нь эдгээр бүх нөхцөлийг дагаж мөрдөнө.

**I Бүлэг — Ажилтан****19.401. Техник үйлчилгээний ажилтны үнэмлэхийг дахин шалгах**

Хэрэв Дарга тухайн үнэмлэх эзэмшигчийн ур чадварыг тогтоох хэрэгтэй гэж үзвэл, ИНД-66-ийн дагуу олгосон аливаа үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэл эзэмшигчийг дахин шалгаж болно. Аливаа дахин шалгалтын үр дүнд, хэрэв шаардлагатай бол, Дарга тухайн үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэлийг өөрчилж, эсхүл цуцалж болно.

**19.403. Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн ажлын цагийн хязгаарлалт**

Дарга, дараах онцлогийг харгалзан, нислэгийн хөдөлгөөний удирдагчийн албан үүргээ гүйцэтгэх ажлын цагийн үргэлжлэх хугацаанд хязгаарлалт тогтоож болно:

(1) тухайн гүйцэтгэх ажлын байрны төрөл;

(2) тухайн ажил үүргийг өдрийн аль цагт гүйцэтгэх;

(3) тухайн байрлал, нислэгийн хөдөлгөөний нягтаршил, эсхүл тухайн удирдагчийн шаардагдах оюуны төвлөрөлтийн түвшинд нөлөөлөх бусад хүчин зүйлд.

**19.405. Туршин нисгэгч**

Дараахаас бусад тохиолдолд, этгээдэд агаарын хөлгийн маягийн анхны загварыг шалгах, эсхүл агаарын хөлгийн туршилтын нислэгт туршин нисгэгчийн үүрэг гүйцэтгэхийг хориглоно:

(1) тухайн этгээд нь ИНД-61-ийн дагуу олгосон хүчинтэй нисгэгчийн үнэмлэх, эсхүл хүлээн зөвшөөрсөн зөвшөөрөл эзэмшдэг ба тухайн төлөвлөж буй маягийн анхны загварыг шалгах, эсхүл туршилтын нислэгт туршин нисгэгчийн үүрэг гүйцэтгэхийг Дарга зөвшөөрсөн байх; эсхүл

- (2) тухайн агаарын хөлөг нь микролайт бөгөөд, хэрэв тухайн байгууллагын ИНД-149-ийн гэрчилгээ нь, хийгдэх гэж буй маягийн анхны загварыг шалгах, эсхүл туршилтын нислэгийн зөвшөөрлийг туршин нисгэгчид олгох эрхийг тухайн эзэмшигчид олгодог бол, микролайтын байгууллагаас тухайн зорилгоор эрх олгогдсон этгээд байх; эсхүл
- (3) тухайн агаарын хөлөг нь глайдер бөгөөд, хэрэв тухайн байгууллагын ИНД-149-ийн гэрчилгээ нь, хийгдэх гэж буй маягийн анхны загварыг шалгах, эсхүл туршилтын нислэгийн зөвшөөрлийг туршин нисгэгчид олгох эрхийг тухайн эзэмшигчид олгодог бол, глайдерын байгууллагаас тухайн зорилгоор эрх олгогдсон этгээд байх.

#### **19.407. Нөөц**

#### **19.409. Глайдерын ажилтан**

(a) Глайдерын нисгэгчийн дараах ангилал эзэмших болон тэдгээр ангиллын хүчинтэй байхад тавих шаардлага, эрх, хязгаарлалтыг ИНД-д заасан:

- (1) глайдерын сурагч;
- (2) глайдерын мэргэшсэн нисгэгч;
- (3) хөөргөх төхөөрөмжийн нэмэлт тэмдэглэл;
- (4) зорчигч зөөх эрх;
- (5) С категорийн глайдерын багш;
- (6) В категорийн глайдерын багш;
- (7) А категорийн глайдерын багш;
- (8) хөөргөх төхөөрөмжийн зааварчилгаа өгөх нэмэлт тэмдэглэл;
- (9) хэрэглэлийн нислэгийн зааварчилгаа өгөх эрх;
- (10) ХНД/IFR-ээр нисэх эрх.

(b) Глайдерын инженерийн дараах мэргэшлийг эзэмшихэд шаардлагатай мэдлэг, чадварын шаардлага болон эдгээр мэргэшлийн эрх, хязгаарлалтыг ИНД-д заасан:

- (1) ангилал 2-ын зөвшөөрөл;
- (2) ангилал 3-ын зөвшөөрөл, W, M, болон P дэд зэрэгтэй;
- (3) ангилал 4-ийн зөвшөөрөл, W, M, болон P дэд зэрэгтэй;
- (4) С зэрэглэл;
- (5) S зэрэглэл;
- (6) R зэрэглэл;
- (7) E зэрэглэл, E2, E3 болон E4 дэд зэрэгтэй.



**19.411. Ханг-глайдер болон параглайдерын нисгэгч**

Ханг-глайдер болон параглайдерын нисгэгчийн дараах ангилал эзэмших болон тэдгээр ангиллын хүчинтэй байхад тавих шаардлага, эрх, хязгаарлалтыг ИНД-д заасан:

- (1) эхлэн суралцагчийн зэрэглэл;
- (2) сурагчийн зэрэглэл;
- (3) дунд зэрэглэл;
- (4) ахлах зэрэглэл;
- (5) параглайдерын 1-р зэрэглэл;
- (6) параглайдерын 2-р зэрэглэл;
- (7) параглайдерын 3-р зэрэглэл;
- (8) параглайдерын багшийн зэрэглэл;
- (9) параглайдерын зорчигчийн зэрэглэл;
- (10) Ханг-глайдерын ангилал 1-ын багшийн зэрэглэл;
- (11) Ханг-глайдерын ангилал 2-ын багшийн зэрэглэл;
- (12) тусгай ур чадварын зөвшөөрөл.

**19.413. Микролайтын нисгэгч**

Микролайтын нисгэгчийн дараах ангилал эзэмших болон тэдгээр ангиллын хүчинтэй байхад тавих шаардлага, эрх, хязгаарлалтыг ИНД-д заасан:

- (1) сурагч нисгэгчийн гэрчилгээ;
- (2) А, В, С бүлгийн сурагч нисгэгчийн зэрэглэл;
- (3) дунд түвшний нисгэгчийн гэрчилгээ;
- (4) А, В, С бүлгийн дунд түвшний нисгэгчийн зэрэглэл;
- (5) ахлах нисгэгчийн гэрчилгээ;
- (6) А, В, С бүлгийн ахлах нисгэгчийн зэрэглэл;
- (7) микролайтын нислэгийн багшийн гэрчилгээ (нөхцөлт);
- (8) микролайтын нислэгийн багш;
- (9) А, В, С бүлгийн микролайтын нислэгийн багшийн зэрэглэл;
- (10) эрх бүхий шалгагч (АТО).

--oOo--